

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, САНГИЙН  
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2018 оны 4 сарын 6 өдөр

Дугаар А/63/70

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 148 дугаар зүйлийн 148.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Баривчлагдсан этгээдийн баривчлах байранд байсан хугацааны шууд зардлын хэмжээг тооцох журам”-ыг нэгдүгээр, “Баривчлагдсан этгээдийн шууд зардлын тооцооны хуудасны загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга /бригадын генерал Ц.Амгаланбаяр/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /хурандаа С.Баатаржав/-д тус тус үүрэг болгосугай

3.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Наранцогт/-т тус тус даалгасугай.





## БАРИВЧЛАГДСАН ЭТГЭЭДИЙН БАРИВЧЛАХ БАЙРАНД БАЙСАН ХУГАЦААНЫ ШУУД ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ ТООЦОХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь баривчлагдсан этгээдийн баривчлах байранд байсан хугацааны шууд зардлыг /цаашид “шууд зардал” гэх/ төлөхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.

1.2.Шууд зардлыг тэдгээрт төлүүлэхдээ Зөрчлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад акт болон энэхүү журмыг мөрдөнө.

### Хоёр.Баривчлагдсан этгээдийн нэрийн дансны үйлчилгээ болон байрны шууд зардал

2.1.Баривчлагдсан этгээдийн биед байсан мөнгө, үнэт эдлэл, үнэт цаас зэргийг баривчлах байрны санхүүд шилжүүлэн нэрийн данс нээж хадгалуулна.

2.2.Баривчлагдсан этгээдийн мөнгийг баривчлах байрны төрийн сангийн дансанд хадгалж, тоо бүртгэгч нь орлого, зарлагыг 14 хоногт 1 удаа баривчлагдсан этгээдэд танилцуулна.

2.3.Баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн нэрийн дансанд тушаасан мөнгөнөөс шууд зардалд суутгах бөгөөд үлдэгдлийг тухайн этгээдийг баривчлах төвөөс суллагдах, эсхүл өөр хорих байранд шилжих тохиолдолд түүнд буцаан олгож, тэмдэглэл хөтөлж, баталгаажуулна.

2.4.Баривчлагдсан этгээдийг баривчлах байрнаас гарахад дараахь зардлыг байрны шууд зардалд оруулан тооцно.

- 2.4.1.дулаан, цахилгаан хэрэглүүлэх;
- 2.4.2.халуун хоол, цайгаар үйлчлэх;
- 2.4.3.автомашинаар хүргэх, тээвэрлэх;
- 2.4.4.карт баримт бичиг хөтлөх;
- 2.4.5.усанд оруулах;
- 2.4.6.фото зураг авах;
- 2.4.7.хувцас угаалга;
- 2.4.8.утсаар яриулах;
- 2.4.9.нэрийн дансны үйлчилгээ үзүүлэх.
- 2.4.10 үс авах, засах

2.5.Баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг баривчлах байранд хүлээн авсан огноо, цагаас эхлэн шууд зардлыг тооцно.

2.6.Шууд зардлын хэмжээ нь тухайн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний төрөл, гүйцэтгэлээс хамааран харилцан адилгүй байна.

Гурав. Баривчлагдсан этгээдийн шууд зардлын тооцооны  
санхүүгийн баримт хөтлөлт, хадгалалт

3.1. Шууд зардлыг тооцож авахдаа баталсан загвар бүхий тооцооны хуудсыг ашиглана.

3.2. Баривчлах байрны орлогыг төсвийн байгууллагын төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлэн зарцуулна.

3.3. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т заасны дагуу тухайн тайлант хугацаанд баривчлагдсан этгээдийн шууд зардлын тооцоог баривчлах байрны санхүүгийн албан тушаалтан Төсвийн тухай хуульд заасан хугацаанд орлого зарлагыг тооцож дээд шатны төсвийн эрх захирагчид хүргүүлж, жил бүрийн төсөвт тусгана.

3.4. Шууд зардлыг төлөхтэй холбоотой хөтөлсөн баримтыг холбогдох журмын дагуу архивын нэгж үүсгэн хадгална.

Дөрөв. Баривчлагдсан этгээдийн шууд зардлыг тооцох аргачлал

4.1. Баривчлагдсан этгээдийг байрнаас гарахад энэ журмын 2.4-т заасан холбогдох шууд зардлыг дараахь аргачлалаар тооцно.

4.1.1. дулаан цахилгаан хэрэглүүлэх: Цахилгааны зардлыг тооцохдоо: Баривчлагдсан этгээдийн 1 хоногийн цахилгааны хэрэглээг тооцохдоо УБЦТС ХК-ийн Цахилгаан тооцоолуурын программыг ашиглан хэрэглэсэн цахилгаан хэрэгслүүдийг нь сонгон тооцно. Цахилгааны зардлыг тооцохдоо дараахь томъёогоор тодорхойлно.

$$ХТ = X * (З * К * АК * Y * Т)$$

ХТ - хэрэглэгчийн төлөх төлбөр

X- хоногийн тоо

З - тоолуурын заалтын зөрүү

К – трансформаторын үржих коэффициент

АК – алдагдлын коэффициент

Y – үнэ тариф

Т – НӨАТ;

4.1.2. халуун хоол цайгаар үйлчлэх: Баривчлагдсан этгээдийн хоолны шууд зардлыг тооцохдоо Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, баривчлагдсан этгээд, хоригдлыг хоногийн хоол хүнсээр хангах норм, олгох журам”-ыг үндэслэн хүнсний материалын нормыг тухайн хүнсний материалын нэг бүрийн үнийг худалдан авсан зах зээлийн үнээр тооцно.

Хоолны зардлыг томъёолбол:

$$ХШЗ = X * (ХМ * НБҮ + ХМ * НБҮ + ... ХМ * НБҮ)$$

ХШЗ – Хоолны шууд зардалд төлөх төлбөр, төгрөг

X – Хоногийн тоо

ХМ – Хүнсний материал /Батлагдсан норм/

НБҮ – Нэг бүрийн үнэ;

4.1.3.автомашинаар хүргэх, тээвэрлэх: Баривчлагдсан этгээдийг автомашинаар хүргэж, тээвэрлэхдээ автомашины ашиглалт, шатахуун зарцуулалтад Монгол Улсын Зам тээвэр, аялал, жуулчлалын сайдын /хуучнаар/ 2004 оны 22 дугаар “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норматив”-ын тушаалыг жишиг болгон байгууллагын даргын баталсан нормативыг мөрдөж ажиллана.

$$ТЗ=С*Н100 *Y$$

ТЗ – Тээврийн зардал

С – Спидометрийн заалтын зөрүү /км-ээр/

Н100– 100 км гүйлтэд зарцуулах шатахууны норм

Y – үнэ тариф /тухайн үед мөрдөгдөж буй 1 л шатахууны үнэ/;

4.1.4.карт, баримт бичиг хөтлөх: Баривчлагдсан этгээдэд карт болон бичиг баримт нээхдээ тухайн карт, хавтсыг худалдан авсан үнээр нь тооцно.

$$КББЗ=КТ+ХТ$$

КТ – Картын үнэ

ХТ – Хавтасны үнэ

КББЗ – Карт, бичиг баримтын зардал;

4.1.5.усанд оруулах: Баривчлагдсан этгээдийн нэг удаагийн усанд орох зардлыг тооцохдоо дараахь томъёогоор тодорхойлно.

$$УСЗ=ХЦУ+ХУХД$$

УСЗ – Усанд оруулах зардал

ХЦУ – Хэрэглээний цэвэр ус

ХУХД– Халуун ус халаасан дулаан

$$ХЦУ=ЦУЗ*Тариф$$

ХЦУ=Хэрэглээний цэвэр ус

ЦУЗ= Цэвэр усны заалтын зөрүү /Хэрэглээний цэвэр усны заалт литрээр/

Тариф– Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний хэрэглэгчийн тариф

$$ХУХД /Усны зарцуулалтаар/= ЦУЗлитр * Тариф$$

ХУХД-Халуун ус халаасан дулаан

ЦУЗ- Цэвэр усны заалтын зөрүү /Хэрэглээний цэвэр усны заалт литрээр/

Тариф– Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулааны усны зарцуулалтаар тооцох тариф;

4.1.6.фото зураг авах: Баривчлагдсан этгээдийн фото зургийн цаас, хэвлэх зардлын үнээр нь тооцно.

$$ФЗЗ=ФЦ*Y+ХЗ$$

ФЗЗ-Фото зурагны зардал

ФЦ – Фото цаас /тоо ширхэг/

Y – Үнэ

ХЗ – Хэвлэлийн зардал;

4.1.7.хувцас угаалга: Баривчлагдсан этгээдийн хувцас угаах, индүүдэх зардлыг зарцуулагдсан цэвэрлэгээний материалын зардлаар тооцно.

$$ЦМЗ=ЦМ*Y$$

ЦМЗ-Цэвэрлэгээний материалын зардал  
ЦМ – Цэвэрлэгээний материал /Нормоос гадуур олгосон/  
Ү – Үнэ;

4.1.8.утсаар яриулах: Үүрэн телефоны сүлжээ хооронд болон сүлжээн доторх ярианы тарифаар тооцно.

УЯТ=Тариф\*Минут  
УЯТ-Утсаар яриулсан төлбөр  
Минут – Ярьсан минут  
Тариф– Ярианы тариф /Тухайн үүрэн холбооны/;

4.1.9.нэрийн дансны үйлчилгээ үзүүлэх: Баривчлагдсан этгээд нь нэрийн данс нээлгэж зөвшөөрөгдсөн үйлчилгээг авах ба суллагдахдаа үлдэгдлийг тооцон авна.

4.1.10. үс авах, засах үйлчилгээ үзүүлэх: Баривчлагдсан этгээд нь сард нэгээс доошгүй удаа, зах зээлийн ханшаар тооцно.

$ҮЗЗ = X * \Theta$

ҮЗЗ - үс авах, засах зардал

X - хугацаа

$\Theta$  - өртөг

4.2.Баривчлагдсан этгээдийн нэг хоногийн шууд зардалд үнийн өсөлт нөлөөлөхүйц өөрчлөлт гарсан бол тухай бүр шууд зардлын хэмжээг шинэчлэн батална.

Тав. Баривчлагдсан этгээдийн баривчлах байранд байсан хугацааны зардал төлөлтийн үйл ажиллагаанд тавих хяналт

5.1.Баривчлагдсан этгээд баривчлах төв болон байранд байсан хугацааны зардлаа төлөх чадваргүй, эсхүл төлөхөөс зайлсхийсэн бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.2.9, 148 дугаар зүйлийн 148.2-т заасны дагуу тухайн этгээдээр албадан хөдөлмөр хийлгэж төлүүлнэ.

5.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 148 дугаар зүйлийн 148.2-т заасны дагуу баривчлагдсан этгээдийг аж ахуй нэгж, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан хөдөлмөрлүүлж болох ба хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг "Хоригдлын хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээ, суутгал хийх журам"-ыг баримтлан тооцно.

5.3.Баривчлагдсан этгээдийн хөдөлмөрийн хөлсийг баривчлах байрны дансанд төвлөрүүлэн зохих төлбөр, суутгалыг хийж үлдэгдэл мөнгийг нэрийн дансанд нь төвлөрүүлнэ.

5.4.Баривчлагдсан этгээд баривчлах байранд байсан хугацааны шууд зардлыг төлөөгүй буюу албадан хөдөлмөрлүүлсний хөлс шууд зардалд хүрээгүй эсхүл биеийн эрүүл мэндийн болон бусад шалтгаанаас хөдөлмөр хийгээгүй бол баривчлах төвийн захиргаа төлбөрийн хэмжээг өөрт нь танилцуулж гарын үсэг зуруулан, харьяалах шүүхэд нэхэмжлэл гаргаж, шийдвэрлүүлнэ.

5.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 148.1-т заасан зардлаас дараахь баривчлагдсан этгээдийг эрх бүхий байгууллагын тодорхойлолтоор чөлөөлнө:

5.5.1.60 ба түүнээс дээш насны асран хамгаалах хүнгүй, амжиргааны баталгаажих түвшнээс доогуур;

5.5.2.эрх бүхий байгууллагаас хугацаагүйгээр хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх хугацааг тогтоосон бол;

5.6.Баривчлах байрны нийгмийн ажилтан энэ журмын 5.5-д заасан этгээдээс гаргасан хүсэлт, тухайн орон нутгийн засаг захиргааны, баривчлах байрны эмч, эмнэлгийн болон шаардлагатай бусад байгууллагын тодорхойлолт, үндэслэл бүхий баримт бичгийг судалж, саналаа тухайн нэгжийн даргад танилцуулна.

5.7.Нэгжийн дарга баривчлагдсан этгээдээс гаргасан хүсэлт, нийгмийн ажилтан, эрүүлжүүлэх, саатуулах байрны эмчийн гаргасан саналыг үндэслэн зардлаас чөлөөлөх эсэхийг шийдвэрлэнэ. Зардлаас чөлөөлж шийдвэрлэсэн тохиолдолд тушаал гаргана.

5.8.Баривчлагдсан этгээд шууд зардлаа төлөх чадваргүй нь өдөр тутам тогтоосон хэмжээгээр хооллох, бусдын адил нөхцөлд шийтгэлээ эдлэхэд нөлөөлөхгүй.

5.9.Энэ журмын хэрэгжилтэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүүгийн асуудал хариуцсан нэгж болон дотоод аюулгүй байдал, хяналт шалгалт хариуцсан нэгж, орон нутагт нутаг дэвсгэр хариуцсан Цагдаагийн байгууллагын дарга, нийтийн хэв журам хамгаалах нэгжийн дарга хяналт тавина.

5.10.Баривчлах байрны нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга, нягтлан бодогч энэ журмын хэрэгжилтэд өдөр тутам хяналт тавина.

---oOo---

Хууль зүй, дотоод хэргийн сайд,  
Сангийн сайдын хамтарсан 2018 оны  
...../..... дугаар тушаалын хоёрдугаар  
хавсралт

БАРИВЛАГДСАН ЭТГЭЭДИЙН ШУУД ЗАРДЛЫН  
ТООЦООНЫ ХУУДАСНЫ ЗАГВАР

| №  | Үйлчилгээний төрөл                | Хэмжээ      | Зардал<br>/төгрөг/ | Хураавал зохих |               | Хураасан |               |
|----|-----------------------------------|-------------|--------------------|----------------|---------------|----------|---------------|
|    |                                   |             |                    | Тоо            | Мөнгөн<br>дүн | Тоо      | Мөнгөн<br>дүн |
| 1  | Байр, дулаан цахилгаан хэрэглэсэн | 1 хоногт    |                    |                |               |          |               |
| 2  | Халуун хоол, цайгаар үйлчлэх      | 1 хоногт    |                    |                |               |          |               |
| 3  | Автомашинаар хүргэх , тээвэрлэх   | 1 км        |                    |                |               |          |               |
| 4  | Карт, бичиг баримт хөтлөх         | 1 удаа      |                    |                |               |          |               |
| 5  | Усанд орох                        | 1 удаа      |                    |                |               |          |               |
| 6  | Фото зураг авах                   | 1 удаа      |                    |                |               |          |               |
| 7  | Хувцас цэвэрлэгээ                 | 1 удаа      |                    |                |               |          |               |
| 8  | Утсаар яриулсан                   | 1 минут     |                    |                |               |          |               |
| 9  | Нэрийн дансны үйлчилгээ үзүүлсэн  | 1 удаа      |                    |                |               |          |               |
| 10 | Үс авах, засах                    | Сард 1 удаа |                    |                |               |          |               |

Хүлээн авсан баривчлах байрны ..... албан тушаалтай  
..... цолтой ..... овогтой ..... / ..... /  
нэр, гарын үсэг

Зардал төлсөн ..... овогтой ..... / ..... /  
нэр, гарын үсэг

Хянасан ..... /байгууллагын нэр/ ..... цолтой ..... ажилтай  
..... овогтой ..... / ..... /  
нэр, гарын үсэг

..... Таслах хэсэг  
Дугаар.....

Баривчлах байрны зардалд ..... төгрөг / ..... /  
үсгээр

Зардал хураан авсан баривчлах байрны ..... цолтой ..... овогтой  
..... / ..... /  
нэр, гарын үсэг

Зардал төлсөн ..... овогтой ..... / ..... /  
нэр, гарын үсэг